



Г.ЭРДЭМЭЭ

*Хууль сахиулахын их сургуулийн
Удирдлагын сургуулийн профессорын
багийн ахлагч, профессор, хурандаа*

Брокгауза Ф.А., Ефрона И.А. нарын 1902 онд бичсэн "Большой энциклопедический словарь"-аас та бүхний мэдлэгт зориулан орчуулан хүргэж байна. /XXXIV боть 352—366 / талд

ШОРОН (Хорих газар)

Шорон гэх ойлголт нь (германиар Thurm-орсоор Башня) дараахь байдлаар тодорхойлогддог:

А) Тодорхой утгаар бол гадаад ертөнцөөс тусгаарлагдсан, харуул хамгаалалт бүхий байр бөгөөд шүүхийн болон эрх баригч удирдлагын шийдвэрээр хүмүүсийг албадан байлгадаг байр юм. Дундад зуунаас эхлэн өнөөг хүртэл хөгжихдөө дараах төрлийн шоронгийн хэлбэрүүд бий болжээ. Үүнд:

1. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хэрэгтнүүд болон ёс зүйн зөрчил гаргасан этгээдүүдийн ялыг эдлүүлэх газар.
2. Баривчлах хэлтэс
3. Цаазаар авах газар (Zuchthduser)
4. Цөллөгдөх
5. Урьдчилан хорих шорон
6. Нутаг заагдах
7. Цэргийн гэмт хэрэгтнүүдийн шорон
8. Насанд хүрээгүй этгээдүүдийн шорон
9. Хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй, сэтгэцийн гажигтай хүмүүсийн шорон (Invaliden-Gefdnngnisse)
10. Дамжин өнгөрүүлэх (intermediate prisons ирландийн систем)
11. Улс төрийн гэмт хэрэгтнүүдийн шорон
12. Цэргийн олзлогсдын (Англичуудын өмнөд африк дахь бурчуудад зориулсан бөөнөөр хорих газар)
13. Төлбөрийн чадваргүй өртөнгүүдийн шорон
14. Эрчүүдийн, эмэгтэйчүүдийн шорон гэсэн төрлүүдтэй болж хөгжсөн

байна.

Б). Хийсвэр ухагдахуунаар бол хүний үндсэн эрхэм зүйл болсон эрх чөлөө гэдгийг үгүйсгэж байдгаараа шоронгийн онцлог оршино. Шорон нь шийтгэл болох талаараа ялгарах нь:

1. Шийтгэлийн хугацаагаар- Ямарч хамаагүй хугацаагаар шоронд хорьж болох бөгөөд бүх насаар нь хорих ял хүртэл хугацаанаасаа өмнө суллагдах боломжтой нь делимость (наказание) ачаар юм. Хорих ялын хугацааг улс бүрт судалж үзвэл: Францад 20 жил (репетив гэмт хэрэгтэнд 40 жил), германд 15 жил (Zuchthaus), Белгид жирийн дэглэмд 20 жил, ганцаарчлан хорих бол 10 жил, Голландад 20 жил, харин орост 2 жил шоронд, 6 жил баривчлах хэсэгт

2. Зөвхөн тухайн хэрэгтэнийг цагаатгасан цагаатгал л шийтгэлийг дуусгавар болно. Гэхдээ ямар ч тохиолдолд хоригдож байх хугацаанд шийтгэлийг сэргээх нь арай хялбар байж болох юм. /Хөрөнгийн ялтай улсаас бусдад нь/

3. Хэрэглэхэд хялбар. Цөллөгийн үед хэрэгтнүүдийг нүүлгэн шилжүүлэх, байршуулах гэх мэт элдэв нөхцөл байдал шаарддаггүйгээрээ шорон нь хэрэглэхэд хялбар байдаг.

4. Хүмүүнлэг байдал нь хоригдлуудын нэр төр, хүнлэг чанарыг гутаан доромжлодоггүй.

5. Хүн нэг бүртэй ажилдагаараа ялтан тус бүрийн онцлогийг харгалзан түүний зан чанарыг хялбархан өөрчлөх боломжтой. Үүнийг хэрэгжүүлэхдээ янз бүрийн шоронгийн дэглэм, төрөл бүрийн хорих газруудыг ашигладаг.

6. Ёс суртахууны болон оюуны нөлөөлөл нь. Шоронд гар урлал, засвар, мужааны цех, сургууль ажиллуулж, хоригдлуудад лам нарыг чөлөөтэй оруулан уулзуулж, хоригдлуудтай сэтгэл судлаачид ярилцлага хийх гэх мэт арга хэмжээнүүд явагддаг.¹³

Шорон судлал нь шоронгийн бүтэц, удирдлагын тухай бодит, түүхэн болон онолын баримт мэдээллүүд мөн эрх чөлөөг нь хязгаарлах маягаар хэрхэн шийтгэлийн зорилгодоо хүрэх аргуудыг багтаасан бүхэл бүтэн цогц өвөрмөгц сургаал юм.

Ял өгөх аргаар засан хүмүүжүүлэх үзэл санаа хөгжих тутам шорон судлалын үүрэг, зорилго мөн хөгжин өөрчлөгдөж байна. Шорон судлал нь зөвхөн шоронг судлаж, шүүмжлэхээс түүний хүрээ хязгаарлахгүй. Бүх цаг хугацааны турш үүсэн бий болсон институт, засан хүмүүжүүлэх-шоронгийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг оюун санаа, үйл хөдлөлөөрөө засч залруулах гэсэн институтын үүрэг оролцоо юм.

Эдгээр институтыг нэрлэвэл: Патронаты хамаарагдана. Мөн насанд

¹³ *Tierpsychologie, Gefühlskunde, Science pénitentiaire*

хүрээгүйчүүдийн колони, тусгай засан хүмүүжүүлэх байр, засан хүмүүжүүлэх байр нь хорих ажиллагаанаас суллагдаж эрх чөлөөтэй болж буй хоригдлуудын завсрын, шилжилтийн үе шат юм. Мөн институтад хугацаанаас өмнө суллах, цагдаагийн хяналт дор байлгах зэрэг ажиллагаа хамаарагдана.

Шорон судлал нь дараахь шинжлэх ухааны үр дүнг өргөн ашигладаг. Үүнд:

Сэтгэл судлал¹⁴, хүн судлал¹⁵, эрүүл ахуй судлал¹⁶, төрийн болон хууль зүйн шинжлэх ухаан¹⁷, ёс зүй сурган хүмүүжүүлэх ухаан¹⁸ зэрэг юм. Шорон судлал XVIII зууны төгсгөлд үүсэж эхлэх үед зөвхөн шоронгийн тухай мэдээллийн төдий байв. Энэ үед нэрт зүтгэлтэн, шоронгийн шинэтгэгч Жонн Говард¹⁹ тодрон гарчээ. XIX зууны дөчөөд оноос шорон судлалын хөгжил олон аргачлалаар хөгжиж эхэлсэн байна. Энэ тухай шоронгийн эсвэл пенитенциарний их хурал²⁰ сэдвүүдээс харж болохоос гадна тусгай тогтмол хэвлэлүүдээс уншиж болно.

Эрт дээр үеэс л хоригдол ялгнуудыг хорих байр гэдгээрээ шорон алдартай. Шорон нь хэрэгтэн, олзлогсод, хувь хүн болон төрд өртэй хүмүүсийг хадгалах үүрэгтэйгээс ба бусад шийтгэл болон төрөл бүрийн цаазын гүйцэтгэлийг сайжруулах газар болдог.

14 Сэтгэл судлал, өөрөөр Психологи (эрт. грек. ψυχή — сэтгэсанаа; λόγος — мэдлэг, ухаан) гэдэг нь хүн ба амьтны оюун ухаан, зан үйлийг судалдаг шинжлэх ухааны нэгэн салбар юм. Сэтгэл судлаачид шинжлэх ухааны архыг хэрэглэхдээ шүүмжлэлт хандлага, тогтсон онол дээр тулгуурлах бэлэвч бусад нийгмийн шинжлэх ухааны салбар, тухайлбал социологитой харьцуулахад илүү бага хэмжээнд ашигладаг байна. Сэтгэл судлалын чиглэлээр мэргэшсэн онолч, эрдэмтнийг сэтгэл судлаач гэдэг. Сэтгэл судлаач нь сэтгэл хөдлөл, анхаарал, зан үйл, хуртэхүй, сэтгэцийн эмгэг, сэтгэл засал, харилцаа зэргийг судалдаг шинжлэх ухаан юм. Мөн зарим сэтгэл судлаачид ухамсиргүй зан үйлийг судалдаг. Сэтгэл судлаачид сэтгэл зүйн үйл явцыг судалж уламжар хувь хүн болон нийгмийн хүрээнд оюун санаа хэрхэн боловдөг болохыг ажлж тогтоохыг эрмэлздэг. Сэтгэл судлалын мэдлэг нь боловсрол, амжил эрхлэлт, гэр бүлийн амьдралын үйл явц нүүтчлэн сэтгэцийн өвчнийг эмчлэх зэрэг хүний олон үйл ажиллагаанд хэрэглэгддэг юм. Түүнтэн сэтгэл судлал нь хүний хөгжил, спорто, эрүүл мэнд, аж үйлдвэр, хэвлэл мэдээлэл, эрх зүйн салбарыг судлах зорилгоор дэд салбаруудыг бий болгожээ. Мөн байгалийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны судалгааг авч ашигладаг.

15 Хүн судлал буюу Антропологи (Англиар Anthropology; Оросоор Антропология) гэдэг нь хүн, хүн төрөлхтнийг судлах байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан юм. 1501 онд Германы гүн ухаанч Магнус Хүндт Антропологи (эртийн Грек хэлний антропос хэмээх ἀνθρωπος, "хүн", -логиа хэмээх λόγος, "судлал") гэдэг нэр томъёог анх хэрэглэжээ.

16 Хүрээлэн буй орчны хүчин зүйл нь хүний биед сөрөг болон тааламжтай нөлөө үзүүлж зорилгоор судалдаг эрүүл мэндийн шинжлэх ухаан.


17 Эпикс гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйн талаар асуултуудыг (сайн эсвэл муу, зов эсвэл бүүр, сайн үйл эсвэл муу үйл, хууч дүрэм эсвэл гэмт хэрэг гэх мэт) судлана. Ёс зүй хэмээх ойлголт нь эртний грекийн Ethos буюу хамтран амьдрах, орчин амьдрах газар гэдэг утгатайгаар илэрхийлэгддэг байсан.

18 Эртний Грекийн Παιδαγωγική. — боловсрол олгох урлаг, па-γος нь — бага насны хүүхэд → παιδός — өсвөр насны хүүхэд + -γωγος — гэсэн үг бөгөөд—Хүнийг сургах болон боловсролын шинжлэх ухаан.

19 Джон Говард (англ. John Howard, 1726.09.02-нд Лондонд төрсөн, 1790.01.20-нд Херсонд нас барсан)

— английн хуульч, нэгүүлсэгч ба английн анхны шоронгийн шинэтгэгч, европ дах нийтийн халдварн өвчний судлаач.

20 пенитенциарные конгрессы" гэж харах



Сократын хоригдож байсан эртний шорон

Афины Мильтиад шоронд төрийн өртөн гэгдэх хоригдлууд хоригдож байсан талаар тэмдэглэгджээ. Агуу философич Сократ ²¹Афины шоронд өөрийн цаазыг хүлээн хоригдож байв.

Римд алдарт Сервия Туллиягийн үеэс нэрд гарсан аймшигт газар доорхи зоорь хоригдлуудын зүрхийг шимшрүүлэх бөгөөд түүнийг Туллианум гэж нэрлэдэг. Дундад зуунд ялтнуудыг хорих ажиллагаа өргөн хүрээтэй явагдаж, улс төрийн эсэргүү этгээдүүд, гэмт этгээдүүд, өртнүүд, олзлогсдыг сүмийн байр²², цайз, цамхагууд, хотын захиргааны байранд хорьж цагдаж байв. Лондон дахь Тоуэрын шорон, Венецийн дожей (дожуудын) хашаан доторхи харанхуй шорон, Нюренбергийн хотын захиргааны байрны газар доорхи шорон нь нэр цуутай шоронгуудын тоонд орж байжээ. Загалмайтны аян дайны дараа бий болсон бүх нийтийн ядуурал, хоосролыг дарахын тулд хулгайч нарын гар хурууг тайрах зэрэг хамгийн хатуу шийтгэл ноогдуулаад ч гэмт хэргийг бууруулж чадаагүй нь европт анхны номхотгох байр (Zuchth d user) байгуулахад хүргэжээ.


21 Эртний грекээр Σωκράτης, ойролцоогоор МЭӨ 469-399 онд Афинд амьдарч байсан гүн ухаантан.

22 Дундад зууны Грек κελίον, -ία, κέλλα, Латин sella гэсэн үгнээс гаралтай - "өрөө, пин" гэсэн үг, орсоор keli" а.

Иймэрхүү байр house of correction-ыг 1550 онд Лондонд, улмаар 1588 онд Амстердамд, мөн онд ядуу өнчин хүүхдүүдэд зориулсан тусгай байрыг Нюрнбергт, 1613 онд Любекд, 1615 онд Гамбургт болон 1682 онд Мюнхенд баригдаж тус тус ашиглалтанд орсон байна.

Номхотгох байруудад тэнүүлчид, ядуус, төрөл бүрийн гэмтэнүүдийг хорихоос гадна балмад ааш гаргасан ажилчид, зарц нарыг хүртэл хорьж байв. Ийнхүү номхотгох байранд хоригдогсдын хүрээ тэлэгдэхийн хирээр байрны хүрэлцээ хангалтгүй болж ирсний зэрэгцээ тухайн байр нь садар самуун, шоронгийн тип өвчний үүр уурхай болов.

Ийм гамшигт байдлын дунд XVIII зууны бараг бүх шоронгууд үйл ажиллагаагаа явуулж байжээ. Шоронгийн байр нь тааз намхан, хавчиг, гэрэл гэгээ муутай, агааржуулалт байдаггүй. Эр, эм, хүүхдүүд нэг дор



хамтдаа хоригдоно. Хүнс тэжээлээр дутмаг ердөө л амь зогоох талх-ус өгнө. Цагаан хэрэглэл гэж байхгүй учир хөрсний чийг болсон газар шороон дээр унтацгаана. Английн шоронгийн дүр төрх нэг иймэрхүү байсан талаар Говард бичиж үлдээсэн байна. Бусад улс орнуудад шорон мөн адил бөгөөд түүний дотор Парижийн алдарт Бастилийн²³ шорон ч ийм нөхцөлтэй байв.

Харин Нидерландийн шорон хамаагүй дээр байж.

Нидерландад шоронгийн

нөхцөл болон шийтгэлийг энэрэнгүй талаас нь олж харж, бусдаас илүү эмх цэгцтэй хяналт болон зохион байгуулалтыг хийж чаджээ. 1775 онд Нидерландын Гент хотод баригдсан Maison de force шорон онцлог юм. (Зурагт тус шоронгийн загварыг харуулав). Өдрийн цагаар хоригдлууд хатуу хяналт дор бүгд хамтдаа ажил хийх бөгөөд шөнө нь тус тусын хорих өрөөндөө хоригдоно. Шөнийн цагаар хоригдлуудыг тусгаарладаг нь бас нэг дэвшил болсон байна. Ингэж хоригдлуудыг тус тусад нь тусгаарлаж байгаа нь хоригдлуудын ёс суртахууныг хамгаалах зорилготой. Гентийн шоронд анх удаа засан хүмүүжүүлэх өөр арга хэмжээ хэрэглэсэн нь хоригдлуудыг ёс

²³ Францийн Парис хот дахь Бастилийн шоронг 1355 онд барьж эхэлсэн ба 1370 онд дуусгажээ. Эртний шоронгуудын нэг

суртахууны шинж чанараар нь бүлгүүдэд хуваарилан амьдралд хэрэгжүүлж үзсэн явдал юм.

Гэмт хэрэгтнүүдийг засан хүмүүжүүлэх зорилго тавин ажилласан анхны шоронгоор Гент дах тус шорон шоронгийн түүхэнд тодорсон билээ. Шоронгийн хууль эрх зүй боловсронгуй болохын хирээр шинээр үүсэн бий болж буй зорилтыг хэрэгжүүлэх, хоригдлыг зөвхөн хориод байх бус тэднийг засан хүмүүжүүлэх нь чухал болж ирсэн байна. Ийнхүү шорон нь хэд хэдэн төрөл болон хөгжиж, үндсэн ялгаа нь хоригдлуудыг хорих арга барилд өөрчлөлт оржээ.

А) Нэгдсэн дүгнэлт: Залхаах арга хэмжээ болдогын хувьд хоригдлуудыг ижил дэглэмтэй энгийн хорих байранд байлгадаг. Гэхдээ засан хүмүүжүүлэх арга хэмжээ учраас хоригдлуудыг засан хүмүүжүүлэхийн тулд тэднийг тодорхой хэмжээгээр хамтад нь байлгадаг. Өөрөөр хэлбэл хоригдлыг байнгын хөдөлмөрт сургаж, хорон, эсэргүүцсэн хүсэл зорилгыг нь дарж, нийгмийн сэтгэхүйтэй болгон хүмүүжүүлэх замаар засан хүмүүжүүлэх зорилгодоо хүрдэг. Хэрэгтэнд энгийн ёс зүйд тулгуурласан нийгмийн наад захын сэтгэхүйг суулгахын тулд гадны арга хэрэглэхэд хүрнэ. Нөгөөтэйгүүр хоригдлуудыг нийгэмшүүлэх, хоригдлын сэтгэл дэх хэрцгий үзлийг дарах, мөн хоригдлын эсэргүү үзлийг номхруулж, байнгын хөдөлмөрт сургах шаардлагатай. Энгийн ёс зүйн шаардлага дээр суурилагдсан хоригдлын наад захын нийгмийн мэдрэмжийг авч үлдэн бэхжүүлэх нь чухал. Үүний тулд эрчүүдийг эмэгтэйчүүдээс тусгаарлах, хүүхдийг насанд хүрэгчтэй хамт байлгахгүй байх нь хангалттай. Ингэснээр садар самуун дэлгэрэхээс хамгаалагдах юм.

Өнөө цагт хоригдлуудыг хүйс насаар нь ялгаварлан хорьж байгаа нь бүхий л тохижигдсон шоронгуудын байнга авах ёстой арга хэмжээнд тооцогддог. Ёс суртахууны зорилгодоо хүрэхийн тулд хоригдогсдыг ёс суртахууны завхралын байдлаар нь шатлан ангилах нь зүйтэй. Үүнийг ёс суртахууны шинжээр ангилах гэнэ.

Ингэж ангилах оролдлого нь одоогоор нааштай үр дүнд хүрээгүй л байна. Үр дүнгүй байгаа нь энэ системийг амьдралд нэвтрүүлэх боломжгүй гэсэн үг биш юм. Орчин үеийн шоронгийн үйл ажиллагаатай болон гэмт хэргийн хэлмэгдүүлэлттэй уялдаж чадахгүй байгаагаар холбож үзэх нь зүйтэй. Хэрэгтэн бүрийн сэтгэл зүйд хүрч ажиллаж чадахгүй байгаагаар ч бас холбоотой. Ёс суртахуунлаг шинжээр эрэмбэлэх нь шоронгийн ажилтнуудаас идэвхитэй, ёс суртахууны харьцаагаар хоригдлуудтай харьцах шаардлага тулгардаг юм.

Идэвхитэй ёс суртахууны харьцаатай байхын тулд шоронгийн ажилтнууд сэтгэл зүйд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй ажиглалт, тандалтанд түшиглэсэн бэлтгэлтэй байх шаардлагатай. Одоогоор ийм амжилтанд хүрэх бололцоогүй юм. Тиймэрхүү ангилан эрэмбэлэх

оролдлогыг Бельги, Швейцарь, Прусс, Англи улсад хийж байжээ. Ихэнхдээ хоригдлуудыг сайн, муу, дундчууд гэсэн гурван зэрэглэл болгон ялгадаг. Зарим шоронгуудад арваас дээш групп болгон зэрэглэж байсан бол бусад шоронгуудад олон янзаар зэрэглэж байсан ч тухайн үеийн шоронгийн удирдлага байнгын бүрэн ачаалалтай нөхцөлд ажиллаж, гарын авлага болгох мөн чанараа олж мэдээгүй байснаас болж амжилт гаргаж чадаагүй юм. Иймээс эрэмбэлэх ажиллагаанаас боломжийн арга нь хоригдлуудыг гадаад төрх байдлаар эрэмбэлэх нь дээр юм гэж үзэцгээж эхлэв. Энэ нь шоронгийн ажилтнуудад онц хүнд даалгавар болохгүй сайн талтай ба шоронгийн ажилтнуудад сэтгэлзүйн ажиглалтын ажиллагааг явуулах шаардлагагүй болгосон.

Хоригдлуудыг ажил төрлөөр нь буюу мужаан, слесарь, дархан зэргээр эсвэл байр юм уу, 20-30 хүн гэх мэтээр тоо хэмжээгээр бүлэглэн ялгахад гадна эрх чөлөөгөө алдсан төрөл зүйлээр, үйлдсэн гэмт хэргийн шинж чанараар ялгана. Тухайлбал рецитив болон хүнд гэмт хэрэгтнүүд, хөнгөн гэмтнүүд тус тусдаа байх жишээтэй. Ажил төрлөөр нь эрэмбэлэх Обермайерын зохиосон системийг Мюнхен хотын шорон, харин Обанелягийн зохиосон гэмт хэргийн шинжээс хамаарч эрэмбэлэх системийг Женев хотын шоронд хэрэгжүүлж байв. Обанелягийн системээр гэмт хэрэгтнүүдийг 4 бүлэгт хуваадаг. Үүнд:

- 1) Онц ноцтой ба хүнд гэмт хэрэгтнүүд
- 2) Хөнгөн ялтнууд
- 3) Болчимгүй үйлдлээсээ болж хоригдогсод
- 4) Насанд хүрээгүй хүүхдүүд болон засарч байгаа хоригдлууд.

Ажил төрлөөр нь эрэмбэлэн ангилахыг Швейцарийн С-Галлен Кантон дахь гэгээн Яковын шорон хэрэгжүүлж байжээ. Мюнхены болон С-Галлены шоронгууд засан хүмүүжүүлэх зорилгуудын нэг болох хоригдлуудыг тогтмол байнгын хөдөлмөрөөр хүмүүжүүлэх ажиллагаанд амжилт олж эхэлсэн юм.

Үргэлжлэл нь

Брокгауза Ф.А., Ефрона П.А. нарын 1902 онд бичсэн
Большого энциклопедического словарияс та бүхний
мэдлэгт зориулан орчуулан хүргэж байна.

ЭРТНИЙ ГРЕК, РОМЫН ШОРОН

1.Эртний грект шоронг газар бүрт өөр өөрийн нэрээр нэрлэдэг. Тухайлбал Афинчууд δεσποτήριον²⁴ мөн οἰκῆμα²⁵ буюу ἀναγκαῖον²⁶ хэмээн нэрлэж байв. Дээврийн зохиолчдын²⁷ бичснээс үзвэл δεσποτήριον гэсэн үг нь зөвхөн ганц тоон дээр хэрэглэгдэж байсан байна. Энэ талаар Ульрих Линсиус дүгнэлт хийхдээ Афинд ердөө төрийн ганцхан шорон байсан гэжээ.

Шоронд хорих нь ховор тохиолдолд залхаан цээрлүүлэх ажиллагаа болдог байна. Харин төрийн үйл ажиллагаа, өр төлбөрийн асуудлаар ихэнхдээ албадлагын хэрэгсэл болгон шоронд хорьж байжээ. Мөн урьдчилан саатуулах арга хэмжээнд шоронг ашиглаж байв. Афины шоронд залхаан цээрлүүлэх ажиллагаа явуулж байсныг цөөн тооны эртний баримт байдаг. Түүнд Демосфон²⁸ шоронд хорих нь шийтгэл юм гэж “Солоны хууль²⁹”-ийг иш татдаг.

Тэр хуулиар шийтгэлийг ἀτιμοί³⁰ -ийн шийтгэл гэж тодорхойлдог. Ἀτιμοί нь алдагдсан эрхийг үргэлжлүүлэх бололцоог олгодог. Үүгээрээ Сократ нь өөрт ноогдсон шийтгэлээс сонголт хийх бололцоотой байснаас харгдаж байна. Сократад ἔην ἐν δεσποτηρίῳ³¹ боломж байсан бололтой. Платон өөрийн “Хууль”-даа (Х.908) шоронг 3 төрөл байхаар санал дэвшүүлжээ. Тэдгээрийн нэг нь засаршгүй гэмт этгээдүүдэд зориулсан газар байхаар санаагаа гаргажээ. Ихэнхдээ шоронд хорих нь нэмэгдэл шийтгэл байлаа. Жишээ нь хулгайч хулгайлагдсан эд зүйлийг хоёр нугалж торгууль төлөхөөс гадна тодорхой

24 Хорих (δέσν — холбож унах гэсэн грек үгнээс үүдэлтэй) гэсэн грек үг

25 Оршин суух гэсэн грек үг

26 Албадан байршуулах гэсэн утгатай грек үг

27 Эртний зохиолчид дээврийн хөндийд зохиол бүтээлээ түүрвигдэг байснаас шинхүү нэрлэсэн болов уу (орчуулагч).

28 Демостен-Демосфен (Demosthenes)(МЭӨ 384 оно Афинд төрж, 322.10.12-д Аргеоид, Киласрид нас барсан) Эртний Грекийн аугаа уран итгээгчдийн нэг хэмээгддэг Афины төрийн зүтгэлтэн, ПЛУТАРХ-ын тэмдэглэсэнээр, тэрээр залуудаа ээрүү нэгэн байсан бөгөөд толгойгоо олно зогсоод амандаа жинжиг чухуу хийж дасгал хийсээр хэл яриагаа сайжруулсан гэдэг. Авъяас биег нь бага заруугаасаа тодорсон түүнээр нолоо бүхий хүмүүс итгэлтэй бичүүлдэг байв. Тэрээр бүхий амьдралынхаа туршид ардчиллын зарчмыг хамгаалж ирсэн. Демосфен “Филиппик” (“хилэгнэн бурууцаахуй”) хэмээх алдарт үгээрээ Афинчуудыг II ФИЛИПП-ийг, дараа нь Филиппийн хүү АЛЕКСАНДР-ыг сөрөн тэмцэхийг уриалж байв. Демосфены энэ үйлдэл Филиппийн цаад санааг их тайвшин гэж үздэг ЭСХИИ-ий дургүйцлийг торүүлсэн байв. Демосфен Эсхинийг цоллоот явуулж (330) чадсанч хожим нь өөрөө цоллогдсон (324). МЭӨ 323 оно Александрыг үхсэний дараа түүнийг цоллогдос эргүүлэн дуудсан хэдий ч Александрын залгамжлагч наринас зугаталж явахдаа алина хорлогж үхжээ. 2-р боть 1041 тал

29 Солон хэсгийг уншина уу. 9-д

30 шударга бус гэсэн грек үг

31 шоронд амьдрах гэсэн грек утгатай үг

хугацаагаар шоронд суух нэмэгдэл ялаар шийтгүүлнэ. Шоронг албадлагын хэрэгсэл болгох журам бүр Солон³²-оос өмнө хэрэглэгддэг байсан. Үүрэг хариуцлагаас зайлсхийсэн хүмүүсийг шоронд хорьж байв. Солон хүний эрх чөлөөг хасах энэ хэлбэрийг онцгой тохиолдолд хэрэглэж байжээ. Шоронд хорих хэлбэрт *coercitio*³³ -г зөвшөөрч харь орны этгээд, худалдаачин болон хөлөг онгоцны эздийг хохироосон, хохирол барагдуулаагүй, хэрэг үйлдсэн этгээдүүдийг шоронд хорьж, харин хахуульдагч, тэдэнд үүрэг өгсөн, мөн татаас хурааж авсан этгээдүүдэд цаазын ял оноож байжээ. Чухалажиллагаанд урьдчилан хорих аргыг ашиглаж байв. Ялангуяа гадаадын иргэдийн хувьд заавал гүйцэлдүүлэх арга хэмжээнд тооцогдоно. Хэрэг мөрдөх явцад иргэд эрх чөлөөтэй хэвээр байдаг байжээ. Хүнийг шоронд хорих эрхийг шүүх эдэлнэ.

Шүүх зөвлөл шоронд хорих арга хэмжээг улс төрийн чухал гэмт хэрэг болон хахууль авсан тохиолдолд л хэрэглэдэг байв. Шоронгийн удирдлага нь Афинд арван нэгийн³⁴ зөвлөлийн гишүүнээс бүрддэнэ. Тэдгээр зөвлөлийн гишүүдийн шууд удирдлага дор шоронгийн хуягууд болон зандалчид захирагддаг бөгөөд зандалчид хотын тэг дотор амьдрах эрхгүй. Арван нэгийн үүрэг бол шорон доторх амьдралыг зохицуулах болон цаазын ялыг гүйцэлдүүлэхэд оршино. Афины хоригдлууд их эрх чөлөөтэй. Тэд нийтийн байранд амьдарцгааж эргэлт хүлээн авдаг байсан нь Сократын жишээн дээр харагддаг³⁵.

Дионисий³⁶ болон Панафинеин³⁷ үед хоригдлууд батлан даалтын нөхцөлтэйгээр шоронгоосоо гарч болдог байв. Эрүү шүүлтийг зөвхөн боолчуудад л хэрэглэдэг.

Meier-Schumann, «Der Attische Process» Липсиусын шинээр боловсруулсан (Б., 1882—1886); E. Caillemet, «Etudes sur les antiquités juridiques»

32 Солон-(Solon) МЭӨ 630 оны үед төрж, 560 оны үед нас барсан. Герекийн долоон мэргэжлийн нэг хэмээн амдарчиган Афины төрийн зүтгэлтэн, шинэчлэгч, яруу найрагч. Тэрээр сурвалжигч гаралтай боловч даржигч амьдралтай нэгэн байсан. МЭӨ 594 оны үед АРХОНТ-ын албыг анх хашсан боловч 20-иод жилийн дараа л сая шинэчлэл хийж, хууль тогтоомж гаргах бүрэн эрх мэдлийг олж авсан. Түүний шинэчлэлээр язгууртны засаглал эцэс болж, удал судрын талаас тавигдах аливаа шаардлагыг хүчингүй болгосон ба тодорхой хоронго чинээтэй бүх хүмүүст иргэний харьяалал олгосон. Мөн тэрээр ДРАКОН-ы цаазыг илүү хүмүүнлэг хуулиар сольж, өрийн боолуудыг чөлөөлөн газрыг нь эргүүлэн олгож, мэргэжигч боловсролыг нь хохирсон дэмжиж, зоос мөнгө, жин, хэмжүүрийн тогтолцоог шинэчилсэн. Хэдийгээр бүх талаас гэмдэл мэдүүлж байсан ч гэсэн ард түмэн эдгээр өөрчлөлтийг хүлээж авсан. Солон Афинаас явж 10 жилийн турш аялал хийсэн бололтой. Тэрээр эрхээ ирээд өөрийн садан, хожим ТИРАН болсон ПИСИСТРА-ын талаар афинчууд сэрэмжлүүлж байв. 5 боть 3878 талд


33 таслан сэргийгх гэсэн латин үг

34 oi êvðaka-хэмээн нэрийддэг байв.

35 Сократын цаазын өмнө нөхцөлтэйгөө уулзаж байгаа уран зургийг саналд уу.

36 Эртний пендэжигч МЭӨ 180-МЭӨ 10 он хүртэлх хугацаанд ноёрхаж байсан энэтхэг-грекийн хаант улсын нэгэн хаан <https://ru.wikipedia.org>

37 Домжийн дарь эх Афиныг хүндэтгэн тэмдэглэдэг эртний грекийн баяр




d'Athines» (П., 1865); түүний өгүүлэл δεσμοτήριον в «Dictionnaire des antiquités grecques et romaines» Daremberg et Saglio; Thalheim. «Die Griechischen Rechtsaltertümer» (I сал. 2 дах боть «Lehrbuch der Griechischen Antiquitäten» Hermann'a, Фрейбург, 1884); Ullrich, «Vier platonische Gespräche, Menon, Kriton, der erste und zweite Alkibiades» (Е., 1821); Wachsmuth, «Die Stadt Athen im Altertum» (II боть., I хэсэг, хууд. 383 мөн сл., Лпц., 1890); Smith, «Dictionary of Greek and Roman antiquities» I боть., carcer гэдэг үг нь (Л., 1890); Thonissen, «Le droit pénal de la république Athénienne» (Брюссель, 1876).

2. Эртний Римд шоронг carcer гэдэг байсан. Одоогийн San Pietro in Carcere³⁸ болон San Guiseppe de'Falegnami хоёр сүмийн буурин дээр зөвшөөрөл дарь эхийн сүмийн дэргэдэх Капитолируу өгссөн шатны харанхуй буланг эрт цагт римийнхан carcer гэж нэрлэдэг байжээ.

Энэхүү эртний римийн шорон carcer нь Анк Марцие³⁹ хааны үед баригджээ. Шоронгийн байр нь хаданд ухаж хийсэн хэд хэдэн өрөөтэй байснаас одоо нэг л өрөө нь хадгалагдаж үлджээ. Түүнийг том чулуунуудаар байгуулахдаа дээд хэсгийг нь хүнхэр хэлбэрээр бүтээжээ. Шоронгийн өрөө нь дороо газар доорхи өрөөтэй, тэрхүү өрөө нь дугуй хэлбэртэй, дээд өрөөний шаланд байрлах дугуй нүхээр доод өрөөтэйгөө холбогддог. Газар доорх өрөөг Tullianum (зураг хар), дээд өрөөг robur хэмээн тус тус нэргэдэг байжээ.

³⁸ хориx гэсэн латин үг

³⁹ Ancus Marcius Эртний Римын 4 дэх хаан бөгөөд хаан ширээнд МЭӨ 640–616 он хүртэлх хугацаанд суусан



Үүнээс үндэслэн дүгнэлт хийхэд харанхуйн хана нь царсан гуалингаар бэхлэгдсэн байсан бололтой. Анк Марция-гийн шоронгийн дэргэд *Lautumiae* нэртэй шорон зэрэгцэн оршино. Тэрхүү шорон нь хуучин чулууны олборлох газар дээр баригдаж, цэргийн олзлогсдыг хорьдог байжээ. Шоронд орох шат гишгүүрийг *Scalae Gemoniae* эсвэл *gradus gemitorii*⁴⁰ гэж нэрлэдэг. Энэ гишгүүрүүд дээр цаазлагсдын цогсыг тавьдаг байв.

Бусад эртний ард түмнүүдийн адилаар (түүний дотор грекүүд) римчүүд шоронд хорих нь залхаах арга гэж үзэж байсангүй. Харин шоронг *coercitio*-албадлага гэж тэд үздэг байв. Далимд дурьдахад Сенат нь цаазаар авах ял ихдэж бусад шийтгэлүүд хөнгөдөөд байгаа тохиолдолд шоронд хорих арга хэмжээнд хүрдэг байжээ.

Эзэн хаант засаглалын үед шоронд суулгах нь шийтгэлд тооцогдож байв. Тэнд *perpetua* ба *temporaria vincula*⁴¹ үйлчилж байлаа. Шоронд хорих нь хуулиар зохицуулагдах ёстой ч амьдрал дээр болохоор нөхцөл байдал ямар байхаас ихээхэн хамаарна. Хуулийг амьдралд ягштал баримталж байсангүй. Шоронд хорих ялыг санааны зоргоор олгодог, цаг тухайд нь цуцлах нь хэвийн үзэгдэл. Эсвэл тодорхойгүй удаан хугацаагаар хорих явдал байжээ. Шоронд хорих маягаар мөрдөн шалгах ажиллагааны урьдчилан хорих ажиллагаанд ч хэрэглэж байв. Хувийн болон фискаль эрх зүйн хувьд шоронд суулгах нь нөлөөлөх арга хэмжээ болж өр төлбөрийг барагдуулахад ашиглана.

⁴⁰ шатлалын гишгүүрүүд гэсэн үг

⁴¹ түр зуурын ба байнгын холбоо

Христуг төрөхөөс өмнө II зууны үед шорон нь магистратын⁴² цааз гүйцэтгэдэг газар болсон байна. Цаазыг ил гүйцэтгэдэггүй. Энэхүү аргаар эмэгтэйчүүд болон дээд давхрагынханыг цаазалдаг. Цаазлах арга нь өлсгөх буюу амсгааг нь боох аргыг хэрэглэдэг. Эрх чөлөөг нь хязгаарлах анхны арга хэлбэр болох хөл дөнгө⁴³ ба гинжлэх⁴⁴ арга нь эхэндээ цэргийн олзлогсдын эсрэг хэрэглэж байснаа сүүлд энгийн иргэдэд хэрэглэх болжээ. Шоронд хоригдогсдыг гавлах, гинжлэх зайлшгүй шаардлага байгаагүй ч хорихдоо гавлах, гинжлэх аргыг хослуулан хэрэглэх нь элбэг байв.

Гинжлэх ажиллагаанд гинж⁴⁵, хөлийн дөнгө⁴⁶, хүзүү хөлийг холбосон гинж⁴⁷, сур⁴⁸, модон дөнгө⁴⁹ хэрэглэдэг. Төрийн шоронд хорихоос гадна магистраты-гийн байранд онцгой хэлбэрийн хорих ажиллагаа явуулдаг. Түүнийг дур зоргоороо баривчлах-custodia libera⁵⁰ гэх ба энэ төрлийн хорих ялыг эрхэм дээдсүүдэд ногдуулдаг. Хүний эрх чөлөөг хязгаарласан илүү найдвартай энэрэнгүй хэлбэр нь эзэнт хаант засаглалт эрин үед оршиж байлаа. Боолчуудад сахилгын шийтгэл ял оноохдоо хувийн шоронгийн онцгой хэлбэрийг аж ахуйн дэргэд ажиллуулж байв. Шөнөдөө хэрэгтнүүдийг шоронд хориод, харин өдөр болоход гинжтэй боолчуудаар ердийн ажлыг нь хийлгэнэ.

Бүгд найрамдах чуудын үеийн 2-р хагаст шоронг хянах ажиллагааг tresviri capitales⁵¹ хэмээн нэрлэгддэг зөвлөлд христийн он тооллоос өмнөх 289 онд даалгажээ. Бүгд найрамдахчуудын үеийн төгсгөлд зөвлөлийн үйл ажиллагаа хумигдсан байна. Улмаар эзэн хаант засаглалын үед гэмт хэрэгтнүүдийг хариуцах ажил хотын захирагчид шилжсэн ба магистратура байсан боловч ёс төдий болсон иржээ.

Эзэн хаант засаглалын үед шоронг цэргийнхэний эрх мэдэлд шилжүүлэн хариуцуулах болов. Хоригдлуудыг төрийн шоронд хорихоос гадна хувийн шоронгууд, тусгай хуарангуудад хорьж байв. Шоронг харгалзах ажлыг бага тушаалын офицерууд гүйцэтгэх бөгөөд тэдгээр бага тушаалын офицерууд хотын захирагчийн⁵² мэдэлд буюу гал командын захирагчийн

42 Магистраты- Эртний Ромын төрийн албан тушаалтан

43 compedes, pedicae латин үг

44 Catene латинаар

45 Manicae латинаар

46 compedes, pedicae латинаар

47 Nervi латинаар

48 Boiae латинаар

49 Columbaria латинаар

50 цагаан хорих эрх чөлөө латинаар

51 praefectus vigilum латинаар

52 Адриан-Публий Азгий Адриан (Hadrian; Caesar Traianus Hadrianus Augustus; Publius Aelius Hadrianus) (МЭ 76.01.24-нд Бетик, Италид төрж. 138.07.10-д Неаполийн ойролцоох Байд нас барсан) Ромын эзэн хаан (118-138). ТРАЯАН-ыг зээ дүү бөгөөд залгамжлагч. Олон жилийн хуйвалдаан, олоо явуулгын эцэст Траяныг нас барахын өмнөхөн түүнд үрчилэгдэн уямаар залгамжлагч нь болсон. Адриан Сенат дахь ооройг нь эсрэгүүчлэгчдийг цагаар авч, Армен, Мэсопотамыг байхдан дагуулахаар Траяаны эхлүүлсэн аян дайнаас татгалзан цэргээ татаж Мауритан, Партид дээдсэн үйлээнийг үл ажрав. Тэрээр олон газраар аялсан

мэдэлд байв. Шоронгийн дээд удирдлагыг эзэн хааны бие хамгаалах торгон цэргийн захирагч гүйцэтгэнэ. Цэргийн баривчлах ажиллагаа нь эрх зүй болон удирдлагын хувьд «custodia libera» хэлбэрт ойр, хүнд бус гэмт хэрэгт тооцогдох бөгөөд шившигтэй үйлдэлд тооцогдохгүй. Нилээдгүй тохиолдолд баривчлагдсан этгээд хуаран дотор нэг цэргийн хяналт дор хоригдоно. Хоригдлуудтай харьцах харьцаа нь тэдгээрийн эд хөрөнгө нийгэмд эзлэх байр сууриас их хэмжээгээр хамаарна. Мөн хянагч нарын бүрэлдэхүүн ч үүнд нөлөөлж байв. Ядуус, доод гаралтай хүмүүс маш хүнд нөхцөлд байдаг байв.

Адриан⁵³ бүх насаар хорих ялыг хориглосон, Константин⁵⁴ христын тооллын өмнөх 320 онд мөрдлөгийг түргэтгэх, урьдчилан хорих ажиллагааг богиносгох үүднээс хоригдогсад чөлөөтэй хөдлөхөд саад болохгүй байхаар гинжлэх арга сэдэж хэрэглэсэн байна.

бөгөөд олон амжилтын ихэнх нь харь оронд аялсантай нь холбогддог. АДРИАНЫ ХЭРЭМ-ийг барих ажлыг эхлүүлж, Алжир болон бусад газар биечлэн очиж цэргээ сурсан бэлтгэгдэж байв. Герегийн соёл иргэнийн бишрэгч тэрээр Афин дахь Зевсийн сүмийн барих ажлыг дуусгаж, герег хотуудын холбоог байгуулсан. Дэлгид томоохон байгуулалж босгох хөтөлбөрийг эхлүүлж ЭЛЕВСИНИЙ ШИДИЙН ШҮТЛЭГ-т оржээ. Залуу нохор АНТИНОЙГОО Нил мөрөнд живж нас барсанд (130) маш ихээр ганцуудаж эзэнт улс даяар залуу хөвгүүний хөшөөг босгуулсан бөгөөд үүнийг даган элдэв шүтлэгч өргөн дэлгэрсэн. Адриан залгамжлагчаараа АНТОНИЙ ПИЙ-г нэрлэж, харин түүний халааг МАРК АВРЕЛИЙ авахаар сонгожээ. Британика нэвтэрхий толь. 1 боть 2011 он. 45 тал

53 Адриан-Публий Азлий Адриан (Hadrian; Caesar TraianusHadrianus Augustus; PubliusAeliusHadrianus) (МЭ 76.01.24-но Беттик, Италид төрж, 138.07.10-д Неаполын ойролцоох Байд нас барсан) Ромын эзэн хаан (118-138), ТРАЯАН-ы эр дүү бөгөөд залгамжлагч. Олон жилийн хүйвалдаан, дал явуулжын эцэст Траяаныг нас барахын өмнөхөн үүнд үрчлэгдэн улмаар залгамжлагч нь болсон. Адриан Сенат дахь өөрийг нь эсэргүүцэгдийг цагаар авч, Армен, Месопотамыг байлдан дагуулахаар Траяаны эхлүүлсэн аян дайнаас татгалзан цэргээ татаж Мавритан, Партид дэгдсэн үймэгнийг үл ажрав. Тэрээр олон газраар аялан босгоод олон амжилтын ихэнх нь харь оронд аялсантай нь холбогддог. АДРИАНЫ ХЭРЭМ-ийг барих ажлыг эхлүүлж, Алжир болон бусад газар биечлэн очиж цэргээ сурсан бэлтгэгдэж байв. Герегийн соёл иргэнийн бишрэгч тэрээр Афин дахь Зевсийн сүмийн барих ажлыг дуусгаж, герег хотуудын холбоог байгуулсан. Дэлгид томоохон байгуулалж босгох хөтөлбөрийг эхлүүлж ЭЛЕВСИНИЙ ШИДИЙН ШҮТЛЭГ-т оржээ. Залуу нохор АНТИНОЙГОО Нил мөрөнд живж нас барсанд (130) маш ихээр ганцуудаж эзэнт улс даяар залуу хөвгүүний хөшөөг босгуулсан бөгөөд үүнийг даган элдэв шүтлэгч өргөн дэлгэрсэн. Адриан залгамжлагчаараа АНТОНИЙ ПИЙ-г нэрлэж, харин түүний халааг МАРК АВРЕЛИЙ авахаар сонгожээ. Британика нэвтэрхий толь. 1 боть 2011 он. 45 талд

54 Константин I-Флавий Валерий Константин. (МЭ 280.02.27д Мези, Ниссет төрж, 337.05.22-д Битини, Никомедийн ойролцоох Анкиронид нас барсан) Ромын христын шашинт анхны эзэн хаан. I КОНСТАНТИН ХЛОР-ын ууган хүү нэрээр залуу насныхаа ихэнх хугацааг ДИОКЛЕТИАН-ы оронд өнгөрөөсөн. Ханы угсаа залгамжлагч болоогүй учраас эзэн хаан болохын тулд тэрээр оороо эвсэж барин тэлжсэн. 312 онд Ромын гадна Милвийн гүүний нуулаандаа ялж Баруун улсын эзэн хаан болжээ. Тэнгэр засалмай бий болж, in lhnos-signovinces ("Үүгээр байлдан дагуул") гэсэн бичиг үзэгдсэн бөгөөд үүний дараа Константин христийн шашинд орсон эх домог бий. 313 онд ЛИЦИНИЙ-н халмаар христийн шашныг хүлээн зөвшөөрөх тухай Миланы зарлигийг гаргасан. Тэрээр мөн христийн сүмүүдэд газар олгож, тусгай эрх ямба эдлүүлэх болжээ. ДОНАТИЗМ, АРИАНИЗМ тэрэг нэрс үхнийг эсэргүүцж, НИКЕЙ-н зөвлөлийг зарлан хүрэлдүүлжээ. Лицинийг ялж, цагаар авсаны дараа Зүүн улсыг мэдэлдэв авч цор ганц эзэн хаан болсон. Тэрээр нийслэлийг Ромоос Визант хотруу шилжүүлж КОНСТАНТИНОПОЛЬ (324) хэмээн нэрлэсэн. 326 онд эхнэр, ууган хүү хоёроо тодорхойгүй шалтгаанаар хорооложээ. Константин Ромын язгуур шүтлэгийн тайлагд оролцохоос татгалзсаны улмаас ромчуудын дурсуудыг төрүүлсэн бөгөөд Ромд дахин хэзээ ч очоогүй. Түүний ивээл дор христийн шүтлэг дэлхийн шашин болж эхэлсэн. Үнэн алдартны сүм хийд Константиныг эгзэгнээнд өргөмжилжээ. Британика нэвтэрхий толь. 3 боть 1607 талд

Мөн хоригдлуудыг тодорхой цагт эрүүл агаарт гаргаж салхилуулах, тэднийг өлсгөлөнгөөр тамлахыг цээрлэж, харанхуй нөхцөлд хорих, тэдэнтэй муухай харьцахыг хориглов. Констанцийн үед (МЭ 340 он) хоригдлуудыг хүйсээр нь ялгаварлан хоригдог болсон бол Валенте (МЭ 364-378 онд), Грациане (МЭ 375-383 онд) мөн Валентиане II (МЭ 375-392 онд) үед хоригдогсдын байдлын тухай жил бүр тайлан гаргаж байхыг шоронгийн хянагч нарт даалгажээ. Ерөнхийдөө христ хаадууд шоронгийн амьдралын хүнд нөхцлийг хөнгөвчлөх, хоригдлуудтай нигүүлсэнгүй ханддаг болгохын төлөө хуулийн болон өөрийн хувийн шалгалт явуулж байв.

Ср. А. W. Zumpt, «Das Criminalrecht der Römischen Republik» (Б., 1865—69); егo же, «Der Criminal process der Römischen Republik» (Лпц., 1871); Krauss, «Im Kerker von und nach Christus» (Лпц., 1895); Reber, «Ruinen Roms und der Campagna» (Лпц., 1863); Hitzig, «Carcer» — нийтлэл Pauly-Wissowa's «Real-Encyclopädie der Klassischen Altertumswissenschaft» (III боть., хууд. 1576 мөн слл., Штутгарт, 1899); Humbert, «Carcer» (нийтлэл «Dictionnaire des Antiquités Grecques et romaines» Daremberg et Saglio); Th. Mommsen, «Römisches Strafrecht» (Лпц., 1899).